

# НУТГИЙНХНЫ МАНЛАЙЛЛААР ХӨГЖИЛД ХҮРЭХ 8 АЛХАМ

“НУТГИЙНХАН МАНЛАЙЛАН ХӨГЖИЛД ХҮРСЭН НЬ” 8 улсын 800 иргэнийг хамарсан хамгийн өргөн цар хүрээтэй хийгдсэн судалгааны дүнд үндэслэн нутгийн иргэдийн мэдлэг, туршлага, оролцоотойгоор хөгжлийн үр ашгийг хэрхэн олон хүнд хүртээж болохыг үзүүлж байна.

## 8 ХӨГЖИЛД ХҮРГЭХ, ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ ХАНДЛАГЫГ СОНГОХ

“Хүний эрхийг хүндэлсэн цагт л ядуурал эцэслэгдэнэ.”

Хөгжлийн төслийн үр ашиг нутгийн иргэдийн амьдралын чанар дээрдсэн, хүний эрхийг хүндэлж, хамгаалж чадсан эсэхээр хэмжигдэнэ.

## 7 ХОХИРОЛ УЧРУУЛСАН БОЛ ХАРИУЦЛАГА ТООЦОХ

“Хаа сайгүй ухахыг хөгжил хэмээн засгийн газар боддог. Гэтэл энэ нь хөгжил биш, харин аажмаар биднийг ирээдүйгүй болгож байна.”

Төслийн талаар гомдол хэрхэн гаргах тухай мэдэхгүй.

Өөрийн гэр, газар болон алдагдах, устгах бусад нөөцийн бодит үнэ цэнийг тодорхойлох үнэлгээний үйл ажиллагаанд оролцуулаагүй.

## 6 НУТГИЙНХНЫ МОНИТОРИНГИЙН МЭДЭЭЛЛИЙГ АШИГЛАХ

“Нийтийн эрх ашгийг зөрчиж, мөн бохирдол үүсгэж байсан компаниудыг бид илчилсэн. Байгаль орчны бохирдол үүсгэсэн компанийг шүүхэд өгсөн.”

## 5 НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭЛТЭНД ӨӨРИЙН ХӨГЖЛИЙН ТӨСӨЛ МЭТ ХАНДАХ

“Тэд нүүлгэн шилжүүлэлт гэж нэрлэдэг ч бидэнд шилжих газар өгөөгүй. Бага хэмжээний мөнгө өгсөн, тэрийг нь бид хүсээгүй.”

## 1 ИРГЭДИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНӨӨС ЭХЛЭХ

“Зөвхөн засгийн газрын түшмэдтэй бус төслийн нөлөөлөлд шууд өртөх иргэдийн санал бодол, хүсэл санаачлагад тулгуурлан зөвлөлдөх.”

Хөгжлийн төсөлд санал хүсэлтээ илэрхийлэх боломж огт олдож байгаагүй.

## 2 БОДИТ, ЦОГЦ ОРОЛЦООНЫ СААДЫГ АРИЛГАХ

“Иргэдэд чөлөөтэй ярих боломж олгох ба уншиж хоорондоо зөвлөлдөх хугацаа өгч мэдээллийг урьдчилан тараах хэрэгтэй.”

Албадлага, дарамтын улмаас бид нүүхээс өөр аргагүй болсон.

## 3 ХҮНИЙ ЭРХИЙГ ДЭЭДЛЭХ ТӨСЛИЙГ СОНГОХ


“Тогтвортой амьжиргааг хадгалж байгаль, экологид сөрөг нөлөөгүй төсөл боловсруулах.”

Хувийн компаниуд ашиг олох зорилготой боловсруулсан төсөл гэж итгэж байна.

Тэд улсын болон бүс нутгийн хөгжлийн тэргүүлэх асуудлын талаар зөвлөлдөж үзээгүй.


## 4 ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ЯВЦАД НУТГИЙНХНЫ МЭДЛЭГИЙГ ТУСГАХ

“Төслийн нөлөөлөлд өртөх иргэд төлөвлөлтийн үйл явцад зайлшгүй оролцох ёстой. Тэд л орон нутгаа мэднэ.”



INTERNATIONAL  
ACCOUNTABILITYPROJECT

IAP's Global Advocacy Team Initiative нь нутгийнхан манлайлсан судалгаа хийх, мөн хөгжлийн талаарх ойлголт ба хэрэгжилтийг өөрчлөхөөр нутгийнхныгаа дайчлагч хөгжлийн төслийг хамгийн түрүүнд мэдэрч байгаа нутгийн идэвхтэн зохион байгуулагчдыг нэгтгэж байна. Хамтарсан ажлын үр дүнд хөгжлийг бий болгох аргыг өөрчлөх тухай дүгнэлт болон зөвлөжүүдийг багтаасан бүрэн хэмжээний тайлан гаргасан билээ. Дараахь линкээр бүрэн тайланг уншина уу: [bit.ly/backtodevelopment](http://bit.ly/backtodevelopment).



# ЭРТЛЭН СЭРЭМЖЛҮҮЛЭХ СИСТЕМ

## Early Warning System

Хөгжлийн донорууд болон тэдгээрийн төслүүдийн үйл ажиллагаа нь тухайн нутгийн газар ус ба ард иргэдэд хэрхэн нөлөөлөх талаар хүртээмжтэй, цагаа олсон мэдээлэл байдаггүй нь даян дэлхийн хүн амд тулгарч буй томоохон асуудал болоод байна.

Эртлэн сэрэмжлүүлэх систем нь хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжихээр төлөвлөгдөж буй, хүний эрх ба байгаль орчинд халдах магадлалтай төслийн талаар орон нутгийнхан болон тэднийг дэмждэг байгууллагуудыг баталгаатай мэдээллээр хангах, нөлөөллийн стратегиа төслийн санхүүжилт нь батлагдахаас өмнө боловсруулах, үр дүнтэй нөлөөлөхөд нь туслах зорилготой юм.

Эртлэн сэрэмжлүүлэх систем нь нутгийн иргэд, тэднийг дэмждэг байгууллагуудтай мэдээлэл, зөвлөлгөө, арга хэрэгслүүд болон нөөцийн мэдээлэл солилцон хөгжлийн оролцогч талуудад түгээдэг. Солилцох мэдээлэлд хөгжлийн санхүүгийн байгууллагуудын төслийн болон түүнд оролцогч хувийн хэвшлийн талаарх мэдээлэл мөн нутгийнхны өөрийн судалгааны мэдээлэл зэрэг орно.

Хэдийгээр Эртлэн сэрэмжлүүлэх систем нь 13 хөгжлийн санхүүгийн байгууллагын төслүүдийн мэдээллийг нягтлан оруулж, дүгнэн стандартчилдаг ч энэ нь зөвхөн мэдээллийн сан биш юм. Эртлэн сэрэмжлүүлэх систем нь орон нутгийн хөгжлийн тэргүүлэх чиглэл болон кампанит ажилд шаардлагатай мэдээлэл хүргэхийг эрмэлзэж хөгжлийн төлөвлөлт дээрээс доош явагдаж байгааг өөрчлөх нутгийнхны санаачлагыг дэмжих зорилготой.

Эртлэн сэрэмжлүүлэх систем нь орон нутгийн хөгжлийн тэргүүлэх асуудлыг тодорхойлж, тактикийн дэмжлэг үзүүлэх, нутгийнхны авах нэгдмэл арга хэмжээнд тулгуурлана. Шийдвэр гаргагчдад хүрч ажиллах, нутгийнхны өөрийн судалгаа гүйцэтгэх, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын хөшүүрэг болсон санаануудыг ойлгох, гомдол гаргах, орон нутгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох зэрэг нь нутгийнхны авах нэгдмэл арга хэмжээнд багтаж болох юм.

Төлөвлөгдөж буй төслүүдийн талаарх шинэ мэдээлэл болон нийтийг уриалан нэгтгэхэд үзүүлэх дэмжлэг зэрэг нь орон нутгийн өөрийн эрх ашиг ба кампанит ажлаа тодорхойлоход нь мэдээлэл болж өнөөдөр хөгжлийг хэрэгжүүлж байгаа байдлыг өөрчлөх юм. Эртлэн сэрэмжлүүлэх систем нь нутгийнхны өөрсдийн хүсч, төсөөлж байгаа хөгжлийг тодорхойлоход шаардагдах мэдээлэл ба өргөн хүрээтэй чиг хандлагын дүн шинжилгээгээр эртлэн хангаж тавуу тал олгох зорилготой.

Илүү мэдээллийг [www.rightsindevelopment.org/ews](http://www.rightsindevelopment.org/ews)-ээс, эсвэл [ews@rightsindevelopment.org](mailto:ews@rightsindevelopment.org) и-мэйл хаягаар авна уу?